



“ЖУУЛЧИН ГОВЬ” ХК

2014 оны 08 сарын 05 өдөр

№ 11

Улаанбаатар хот

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИД

Тайлан хүргүүлэх тухай

Манай компани 2014 оны хагас жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хүргүүлж байна.

Жич: Тайланг хавсаргав.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



П.МӨНГӨНЦЭЦЭГ

“Жуулчин говь” ХК-ийн 2014 оны хагас жилийн үйл ажиллагааны тайлан

Нэр: “Жуулчин говь” ХК

Хаяг: Өмнөговь аймаг, Ханхонгор сум

Утас: 96658704

Улсын бүртгэлийн мэдээлэл: Улсын бүртгэлийн №: 1110001007, регистр №: 2016273

“Жуулчин говь” ХК нь “Жуулчин говь-1”, “Жуулчин Хонгор” гэсэн жуулчны баазуудтай, улирлын чанартай үйл ажиллагаа явуулж байна. Жилд дунджаар 3500 гадаад, дотоодын жуулчдыг хүлээн авдаг.

“Жуулчин говь-1” жуулчны бааз нь анх 1963 онд байгуулагдсан. Байгуулагдсан цагаасаа хойш өнөөг хүртэл Монгол Улсын аялал жуулчлалын салбарт тогтвортой үйл ажиллагаа явуулж байна.

2000 онд Хонгорын голын дэргэд “Жуулчин Хонгор” жуулчны баазыг шинээр байгуулан өргөтгөл хийж ашиглалтанд оруулсан.

“Жуулчин говь-1” жуулчны бааз нь Улаанбаатар хотоос 560 км, Даланзадгад хотоос 35 км, “Говь гурван сайхан” олон улсын нисэх буудлаас 35 км зайд жуулчдын зорин очих дуртай “Говь гурван сайхан” байгалийн цогцолбор газарт байрладаг. Нэг ээлжиндээ 100-120 хүн хүлээн авах гэр буудалтай, 90 хүнд зэрэг үйлчлэх тохилог ресторантай, гар урлал, бэлэг дурсгалын дэлгүүртэй, 24 цагийн турш ажиллах халуун, хүйтэн устай душ, боловсон бие засах газартай.

“Жуулчин Хонгор” жуулчны бааз нь Баянхонгор аймгаас 420 км, Өвөрхангай аймгаас 390 км, Өмнөговь аймгийн төвөөс 230 км-т үзэсгэлэнт Хонгорын элсний хажууд байгалийн үзэсгэлэнт газар байрладаг. Нэг ээлжиндээ 70 хүн хүлээн авах гэр буудалтай, 50 хүнд зэрэг үйлчлэх тохилог ресторантай, 24 цагийн турш ажиллах халуун, хүйтэн устай душ, боловсон бие засах газартай, сэргээгдэх эрчим хүчээр хангагдсан байгаль орчинд ээлтэй жуулчны бааз юм.

“Жуулчин говь” ХК нь 2014 оны 5 сард жуулчин хүлээн авах бэлтгэл ажилдаа орж улмаар үйл ажиллагаагаа 5 сарын 20-ны өдрөөс 10 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд явуулахаар төлөвлөж, гадаад, дотоодын жуулчид болон гэрээт компанийн ажилтанд үйлчилж байна. Байнгын ажлын байрны 6, гэрээт 15 хүнийг ажлын байраар ханган ажиллаж байна.

Эхний хагас жилийн байдлаар давхардсан тоогоор гадаадын 904, дотоодын 533 аялагч, амрагч хүлээн аваад байна.

2014 онд “Тавантолгой транс” ХХК-аас 24,859,100 төгрөгийн хөрөнгө оруулалтын зээл авч “Жуулчин говь-1”, “Жуулчин Хонгор” баазуудын материаллаг баазыг шинэчиллээ. Мөн “Жуулчин Хонгор” баазын хуучин хогийн цэгийг булуулж, Хонгорын голын 3 жуулчны баазтай хамтран төвлөрсөн нэг хогийн цэгийг байгууллаа. Цаашид “Жуулчин Хонгор” баазын ресторан, 4 ханат гэрүүдийг шинэчлэх, гэрийн буйруудыг цементлэх, гэрэлтүүлгийг сайжруулах, боловсон хүчний асуудлыг шийдвэрлэх зэрэг ажлуудыг хийхээр төлөвлөж байна.

Компани санхүүгийн тайлан тэнцэл, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар болон нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан тооцоог цаг хугацаанд нь гаргаж, татвар, нийгмийн даатгалын байгууллагад хуульд заасан хугацаанд хүргүүлсэн.

2014 оны хагас жилийн байдлаар 25,629,109.00 төгрөгийн орлоготой, 50,625,752.00 төгрөгийн зарлагатай, 24,996,643.00 төгрөгийн алдагдалтай ажилласан

байна. Цалин хөлсний зардалд 1,774,269.00 төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 1,797,890.00 төгрөг, ашиглалтын зардалд 32,101.00 төгрөг, удирдлагын зардалд 26,119,205.00 төгрөг, ХХОАТ-856,600.00 төгрөг, ААНОАТ-52,000.00 төгрөг, НӨАТ-813,000.00 төгрөгийг тус тус зарцуулсан байна. Орлогыг бүтцээр нь авч үзвэл 75 хувийг үйлчилгээний орлого, 25 хувийг буфетны орлого эзэлж байна. Зардлыг бүтцээр нь авч үзвэл 60 хувийг үйл ажиллагааны зардал, 40 хувийг бусад зардал эзэлж байна.

Компанийн үндсэн хөрөнгөнд өөрчлөлт ороогүй. 2014 оны хагас жилийн байдлаар 24,996,643.00 төгрөгийн алдагдалтай гарсан нь харилцагч байгууллагууд гэрээнд заасан хугацаанд мөнгөө шилжүүлээгүйтэй холбоотой юм. Компани их хэмжээний ба сонирхолын зөрчилтэй хэлцэл хийгээгүй.

Компанийн удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн болон нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдэд орсон өөрчлөлт байхгүй. Компанийн хяналтыг жинхэнэ хэрэгжүүлэгч этгээд байхгүй болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Ч.Тогтохбаяр, Д.Хуушаан, А.Цэцэгдэлгэр, Д.Ганболд, Д.Мөнхсайхан, Ч.Мөнхтулга, хараат бус гишүүдээр Н.Энхтуяа, Ө.Будханд, С.Дарханбаатар, төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Д.Мөнхсайхан, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргаар Ц.Сувдаа, гүйцэтгэх захирлаар П.Мөнгөнцэцэг нар ажиллаж байна.

№	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1	П.Мөнгөнцэцэг	Гүйцэтгэх захирал, ня-бо	дээд	1 жил
2	Д.Хуушаан	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	10 жил
3	Д.Ганболд	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	10 жил
4	Д.Мөнхсайхан	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	5 жил
5	Ч.Мөнхтулга	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	3 жил
6	Ч.Тогтохбаяр	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	3 жил
7	А.Цэцэгдэлгэр	ТУЗ-ийн ердийн гишүүн	дээд	10 жил
8	Н.Энхтуяа	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд	1 жил
9	Г.Баттулга	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд	1 жил
10	С.Дарханбаатар	ТУЗ-ийн хараат бус гишүүн	дээд	1 жил
11	Ц.Сувдаа	ТУЗ-ийн нарийн бичиг	дээд	1 жил

ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хуушаан 10,501 ширхэг хувьцаа, ТУЗ-ийн ердийн гишүүн Ч.Тогтохбаяр 1,247 ширхэг хувьцаа эзэмшдэг.

ТУЗ-ийн ердийн гишүүн А.Цэцэгдэлгэр, Д.Мөнхсайхан, Д.Хуушаан, Д.Ганболд нар “Жуулчин говь” ХК, “Мандалговь-Импекс” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр, ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Хуушаан “Монгол савхи” ХК-ийн гүйцэтгэх захирлаар, ТУЗ-ийн ердийн гишүүн Ч.Тогтохбаяр “Монгол савхи” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр, ТУЗ-ийн ердийн гишүүн Д.Мөнхсайхан “Хар хорин интернейшнл” ХХК-ийн гүйцэтгэх захирлаар, ТУЗ-ийн хараат бус гишүүн Ө.Будханд “Мандалговь-Импекс” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр, ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Энхтуяа, С.Дарханбаатар нар “Мандалговь-Импекс” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр, ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ц.Сувдаа “Монгол савхи” ХК, “Мандалговь-Импекс” ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар тус тус ажилладаг.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар нь хоорондоо гэр бүл, ураг төрлийн холбоогүй, нэгдмэл сонирхолгүй болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нарын 70 хувь нь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан. Сургалтанд хамрагдаагүй 3 гишүүнийг 8 сард сургалтанд хамруулахаар төлөвлөж байна.

Хувьцааны 5 буюу түүнээс дээш хувийг эзэмшигч этгээд:

№	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эрхэлдэг ажил / байршил	Эзэмшиж буй хувьцааны хувь
1	Ажнай корпораци	Хан-Уул дүүрэг, 2-р хороо, "Монгол савхи" ХК-ийн байр	32,7%
2	Г.Ганчимэг	"Тавантолгой транс" ХХК-ийн Дэд захирал	22,6%
3	Ч.Цэцэг-Өлзий		19,7%
4	Д.Хуушаан	"Монгол савхи" ХК-ийн Гүйцэтгэх захирал	14,1%

Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2014 оны ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн 2014 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр "Монгол савхи" ХК-ийн хурлын танхимд 13:00 цагт зарлан хуралдуулж, хурлаар хэлэлцсэн асуудлыг хуралд оролцогчдын олонхын саналын эрхээр шийдвэрлэсэн болно. Үүнд:

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны тайлан, Төлөөлөн удирдах зөвлөлийн тайлан, Аудитын хорооны тайланг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар батлав.
2. Компанийн ТУЗ-ийн ердийн гишүүнээр Д.Ганболд, Д.Хуушаан, Д.Мөнхсайхан, Ч.Мөнхтулга, Ч.Тогтохбаяр, А.Цэцэгдэлгэр нарыг, ТУЗ-ийн хараат бус гишүүнээр Н.Энхтуяа, Ө.Будханд, С.Дарханбаатар нарыг тус тус сонгов.
3. Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар ТУЗ-ийн 2014 оны зардлын төсвийг 26 000 000 төгрөгөөр батлав.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэд аудитын хороо, цалин урамшууллын хороо, нэр дэвшүүлэх хороодыг байгуулан ажиллуулж байна.